



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 20 өдөр

Дугаар А/729

Ховд

Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түр түдгэлзүүлэх тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.1, 19.3.5, 19.17.1, 19.21 дэх заалтууд, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх заалт, аймгийн Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын 2020 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг хангасан нь комиссын дүгнэлтээр тогтоогдсон “Мон Кидс” хүүхдийн шүдний эмнэлэг, Баянхангай эмийн сангийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаатайгаар шинээр олгосугай.

2.Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх хугацаа нь дуусч үргэлжлүүлэн ажиллах нөхцөл, шаардлагыг хангасан нь комиссын дүгнэлтээр тогтоогдсон Ховд сумын эмийн эргэлтийн сангийн үйл ажиллагаа явуулах эрхийг 5 жилээр, Дөргөн сумын Марал эмийн сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сэргээж, тусгай зөвшөөрлийг 5 жилээр тус тус сунгасугай.

3.Онцгой нөхцөл байдлын үед байгуулсан хариуцлагын гэрээг зөрчсөн, тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг хангаагүй “Түмний ачит тунгалаг” эмийн сангийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 3 сар хүртэлх хугацаагаар түр түдгэлзүүлсүгэй.

4.Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн газрын дарга, Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын дарга /Ц.Мягмарсүрэн/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

Zax A/729 Ch
02 3258